

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгэнэ.
- (*) тэмдэгтэй даалгавруудыг хөгжим болон дуу сонссоны дараа гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн хариултаас зөвхөн нэг хариултыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ

***К.Орф “Кармина Бурана” зохиолын хэсгээс сонсоод 1-6 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.**

1. *Хөгжмөө сонсоод, ямар урсгал чиглэлээр бичсэн уран бүтээл болохыг сонгоно уу.
A. Импрессионист B. Авангардист C. Экспрессионист D. Модернист
2. *Зохиолын аялгууны шинж төрх чиний бодлоор ямар байна вэ? Тохирохыг сонгоно уу.
A. бадрангуй B. цөхөрсөн C. түгшүүртэй D. эрч хүчтэй
3. *Зохиолын хөгжимдөх хурд ямар байна вэ? Тохирохыг сонгоно уу.
A. Allegro- хурдан B. Moderato- дунд зэргийн
C. Adagio- удаан D. Vivace- гал цогтой
4. *Энэхүү бүтээл нь оршил болон үндсэн хэдэн бүлгээс бүрдсэн бэ?
A. Оршил болон үндсэн 4 бүлэг B. Оршил болон үндсэн 3 бүлэг
C. Оршил болон үндсэн 2 бүлэг D. Оршил болон үндсэн 5 бүлэг
5. *Хөгжмөө анхааралтай сонсоод, зохиолын бүрэлдэхүүнийг сонгоно уу.
A. Гоцлооч, найрал дуучид, монгол үндэсний найрал хөгжим
B. Гоцлооч, симфони найрал хөгжимчид
C. Гоцлооч, Найрал дуучид, найрал хөгжимчид
D. Гоцлооч, найрал дуучид, жазз найрал хөгжимчид
6. *Сонссон зохиолын ноот бичлэгт байгаа “ *f* ” тэмдгийн үүргийг зөв тодорхойлсныг сонгоно уу.



- A. маш зөөлөн B. зөөлөн C. чанга D. маш чанга

***Ш.Өлзийбаяр “Дөрөө” зохиолын хэсгээс сонсоод 6-10 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.**

7. *Зохиолын гол аяыг ямар хөгжмөөр хөгжимдөж байна вэ?

A.



B.



C.



D.




Ноот бичлэгээ ажиглаад, дараах даалгавруудыг гүйцэтгээрэй.

8. *Түлхүүрийн тэмдгийг зөв дарааллаар нэрлэсэн хувилбарыг сонгоно уу.



- A. Ре бемоль, Ми бемоль
C. Соль бемоль, До бемоль
B. Си бемоль, Ми бемоль
D. Си бемоль, Соль бемоль

9. *Аялгууны хөдөлгөөнд тохирох зураглалыг сонгоно уу.



10. *Зохиолын аялгууны хурд чинийхээр ямар байсан бэ? Тохирохыг сонгоно уу.

- A. маш хурдан B. удаан C. тогтуун D. хурдавтар

11. Монгол ардын уртын дуу, лимбэ, морин хуурын эгшиглэгээг барууны симфони найрал хөгжим, эстрад рок хөгжмийн зэмсгүүдтэй хослуулсан уран бүтээл аль вэ?

- A. "Дөрөө" B. "Зуурдын орон"
C. "Эх дэлхийгээ аварцгаая" D. "Шар тэнгисийн тарчлаан"

12. Эстрад урлагийн хөгжмийн төрлүүдийг илэрхийлэх онцлогтой нь зөв харгалзуулсныг сонгоорой.

1	Залуучуудад хандаж, баяр баясгаланг төрүүлэх үндсэн зорилготой урсгал	a. Регтайм
2	Уйтгар гуниг сэтгэлийн гансралыг илэрхийлсэн урсгал	b. Блюз
3	Адармаатай хэмнэл төгөлдөр хуураар хөгжимдөх урсгал	c. Рок
4	Найгах чичрэх гэсэн англи үгнээс гаралтай урсгал	d. Рок-н ролл

- A. 1b 2c 3a 4d B. 1d 2b 3a 4c C. 1c 2d 3a 4b D. 1b 2a 3d 4c

13. Эстрад урлагийн төрлийг хөгжмийн зэмсгүүдтэй нь зөв харгалзуулсныг сонгоно уу.

1. Жазз a. Төгөлдөр хуур
2. Рок b. Банжо
3. Кантри c. Гитар
4. Регтайм d. Саксафон

- A. 1d 2c 3a 4b B. 1d 2c 3b 4a C. 1c 2b 3a 4d D. 1c 2b 3d 4a

14. Орчин үеийн бүжгийн төрлийг зурагтай нь зөв харгалзуулсныг сонгоно уу.

1.



а. фокстрот

2.



б. шейк

3.



с. твист

A. 1с 2б 3а

B. 1а 2с 3б

C. 1с 2а 3б

D. 1а 2б 3с

ХОЁРДУГААР ХЭСЭГ: НӨХӨХ ДААЛГАВАР

2.1 Хөгжмийн зохиолын ноот бичлэгийг ажиглаарай. Сумаар заасан тэмдгүүдийг нэрлэж, зөв байрлуулаарай.

a:

b:

c:

d:

1. Форте- чанга(хүчдэлийн тэмдэг)
3. Фрошлаг- чимэглэл

2. Айзам хэмжээ
4. Крешендо- аяараас чанга